

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ,  
СУРТАЛЧИЛГАА, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТАЛААРХ МЭДЭЭ**

2024 оны 09 сарын 20-ны өдөр

“Баян-Өндөр”

Д/д	Ажлын чиглэл	Үзүүлэлт	Баян Өндөр сум	Бүгд	
1	Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо	526		
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо	4		
		Системчлэл хийсэн хууль тогтоомж	1999-2024 оны Төрийн мэдээлэл, Хууль зүйн мэдээлэл сэтгүүл		
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл заалтын тоо	16		
		Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	38	
			Байгууллага	5	
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	24	
			Байгууллага	4	
2	Аймаг, Сумын Засаг даргын захирамжийн хууль зүйн	Хянаж санал өгсөн аймаг, сумын Засаг даргын захирамж	2009-2023 оны 12 сар хүртэлх Сумын Засаг даргын захирамж, ЗДТГ-		

	үндэслэлийг хянах		ын даргын тушаал		
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон	Хууль зүйн яаманд хянуулж бүртгүүлсэн	1 2023.03.17 Дугаар 6181	
			Хууль зүйн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-	
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг	10		
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо	387		
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа	9		
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал	1		
		Радио, телевизийн нэвтрүүлэг	0		
		Сонин хэвлэлээр сурталчилсан	“Бумбатын мэдээ” сонингоор 0 удаа		
		Бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан	Сумын албан ёсны фэйсбүүк группээр, эрх зүйн хөтөчийн цахим хуудсаар тогтмол явуулж хэвшсэн.		

МЭДЭЭ ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЦЭРЭНСУГАР

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.СОНИНБАЯР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМАНД ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ,  
СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР 2024 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН  
БАЙДЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.09.20.

"Бумбат"

Эрх зүйн сургалт, сурталчилгааны сумын нэгдсэн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Төсөвт байгууллагын дарга эрхлэгч нар, төрийн албан хаагчдад цахимаар болон танхимаар санал авч 2024 оны хууль, эрх зүйн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Авлигын эсрэг хууль, Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргах сургалтыг ЗДТГ-ын эрх бүхий албан хаагчид болон ИТХ-ын төлөөлөгч нарт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн сургалтыг ЗДТГ-ын албан хаагчид, байгууллагын дарга эрхлэгч нарт, Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэгийг төрийн байгууллагын албан хаагч нарт явуулж төсөлд оруулах саналаа төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Захиргааны ерөнхий хууль, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга), Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах журмын сургалтыг төрийн албан хаагч нарт танхимаар сурталчлан ажилласан. Шинэ хоршоо-чинээлэг малчин хөдөлгөөний тухай, Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тухай хуулийн сургалтыг албан хаагчдад, малчдад сурталчлан ажилласан. Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын сургалтыг байгууллагын архив, бичиг хэргийн ажилтан, албан хаагчдад танхим болон цахим хэлбэрээр сурталчилан ажилласан. Байгууллагын "Дотоод журам"-д хуулиар зохицуулаагүй харилцааг хамт олны хурлаар хэлэлцэн тусгаж шинэчлэн батлав. Бодлогын баримт бичиг хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, ЗГХЭГ-ын 2023 оны 98 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулах ярилцлагын тэмдэглэл, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт бичих загвар аргачлалыг албан хаагчдад танилцуулж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн Хяналт шинжилгээний үнэлгээний зөвлөмжийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, төсөвт байгууллагын дарга эрхлэгч, бичиг хэргийн ажилтануудад тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын хавсралт Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу албан хаагчдын хувийн хэргийн шинэчлэлт, ЗГХЭГ даргын 2023 оны 98 дугаар тушаалын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах журмын сургалт, зөвлөмж өгч ажилласан. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө биелэлтийг тайлагнасан. Шинээр ажилд орсон албан хаагчдад чиглүүлэх зөвлөмж өгч ажилласан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд нээлттэй мэдээллэхээр заасан мэдээлэл, үйлчилгээг байгууллагын цахим хуудсаар болон мэдээллийн

самбараар дамжуулан албан хаагчдын хийж хэрэгжүүлсэн ажил, үзүүлж буй үйлчилгээ мэдээллийг тогтмол иргэдэд ил тод мэдээллэн ажиллаж байна. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн хууль тогтоомжийн сургалт, сурталчилгааг ЕБС-ийн нийгмийн ажилтан, цагдаагийн хэсэг хамтран ахлах ангийн сурагчдын дунд цахим контент хийж сурталчилан ажилласан. Нийгмийн бодлогын мэргэжилтэн, ЕБС-ийн Нийгмийн ажилтан нар ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдад Гэр бүлийн хүчирхийлэл, Бэлгийн дарамт, Үе тэнгийн дээрэлхэлт талаар сургалт, Хүүхэд хамгааллын тухай хууль, Байгаль орчны байцаагч дэлхийн усны өдөртөө холбогдуулан Усаа хайрлан хамгаалахын ач холбогдлын талаар, Цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалтыг өгч 380 сурагчдад мэдлэг олгож ажилласан.

-Эрх зүйн хөтөчийн цахим хуудсаар шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн мэдээ мэдээллийг төрийн албан хаагчид, иргэдэд цахимаар сурталчилан ажиллаж байна. Өвөрхангай аймагт 2024 оны 05 сарын 29-ний өдөр Эрх зүйн хөтөчийг чадавхжуулах сургалтад хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэн ажил хэрэг болгон ажиллаж байна. Эрх зүйн үндэсний хөтөч [www.e-khutuch.mn](http://www.e-khutuch.mn), [legalinfo.mn](http://legalinfo.mn), [d.parliament.mn](http://d.parliament.mn) сайтыг иргэдэд сурталчилан ажилласан. Хяналтанд байгаа Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг байгууллага, албан хаагчид авч нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн.

-Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой шинээр батлагдсан тогтоолуудыг цахимаар сурталчлан ажилласан. Улсын Их Хурлын сонгуульд хэрхэн санал өгөх тухай сонгогчийн гарын авлага бэлтгэн багийн хурлуудаар иргэдэд сурталчилан, мэдээлэл өгч ажиллаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН Ш.ЦЭРЭНСУГАР

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.СОНИНБАЯР

